



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/632

Мөрөн сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдан төсвийг үр ашигтай удирдаж гүйцэтгэлийг хангасан аймгийн Хөгжимт драмын театрын дарга Б.Банзрагч, Нийтийн номын сангийн захирал Э.Даваачулуун, Төв музейн захирал Х.Рагчаа нарт 1 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгосугай.

2. Нэг удаа олгох мөнгөн урамшууллыг хууль журмын дагуу тооцож олгохыг аймгийн Хөгжимт драмын театрын нягтлан бодогч (М.Цэвэлмаа), Нийтийн номын сангийн нягтлан бодогч (Д.Энхсайхан), Төв музейн нягтлан бодогч (Н.Мэндбаяр) нар зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР